



ХЭНТИЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРВАН ДОЛООДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 09

Чингис хот

“Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.13 заалт, Засгийн газрын 2022 оны 419 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арван долоодугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших, иргэд аж ахуй нэгжийг дэмжих “Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Чогсомжавт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо /Л.Батсайхан/-нд даалгасугай.

ДАРГА

Г.ХЭРЛЭНЧУЛУУН



Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 17 дугаар хуралдааны
09 дүгээр тоогоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТООС ОРОН НУТАГТ ШИЛЖИН ИРЖ БҮЙ ИРГЭД АЖ АХУИН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ДЭМЖИХ “НЭЭЛТТЭЙ ХЭНТИЙ АЙМАГ” ХӨТӨЛБӨР Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, орон нутгийг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарсан.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор дээрх бодлогын баримт бичигт нийцүүлэн аймаг, орон нутгийн онцлогийг тусгасан бие даасан хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд аймаг, орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлс, нийгэм, эдийн засаг, техник, технологи, жижиг дунд үйлдвэрлэлийн ололт амжилтыг олон нийтэд мэдээлэн сурталчлах, Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих “НЭЭЛТТЭЙ ХЭНТИЙ АЙМАГ” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын бичиг баримт, үйл ажиллагаа, судалгаанд үндэслэн боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. “НЭЭЛТТЭЙ ХЭНТИЙ АЙМАГ ХӨТӨЛБӨР”-ийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бус нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Хөтөлбөрийн агуулгад аймаг орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилсан, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсон байх;

2.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1. Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, аймаг орон нутгийн талаарх нэгдсэн ойлголт, мэдээллийн нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгож цахимжуулах, төрийн үйлчилгээг ойлгомжтой, шуурхай болгох, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх замаар аймаг, сум орон нутгаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Хөтөлбөр дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1.1. Иргэд шилжин суурьшихад тулгардаг хүндрэлийг бууруулж Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэдийн тоог 10 хувиар нэмэгдүүлэх;

4.1.2. Орон нутагт иргэдийг шилжин суурьшихад дэмжин, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.1.3. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгжийн уялдааг хангах;

4.1.4. Иргэд, олон нийтийн сэтгэлгээ, хандлагад эерэг нөлөө үзүүлэх;

4.1.5 Иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх;

Тав. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

5.1. Хөтөлбөрийг дараах чиглэлд тэргүүн ээлжид хэрэгжүүлнэ:

5.1.1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах чиглэлд идэвх санаачилга гаргах;

5.1.2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

5.1.3. Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

5.1.4. Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах; үйлдвэрлэл, аялал жуулчлал гэх мэт бодит хөрөнгө оруулалт оруулах салбараа эрэмбэлэн хөгжүүлэх, иргэдийн тогтмол орлого олох боломжийг эрэлхийлэх;

5.1.5. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьшин амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөх, амьдрах таатай орчин

бүрдүүлэх, мэдээллээр хангах чиглэлд аймаг, орон нутаг манлайлан оролцож, эдгээрт чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулж тогтмолжуулах;

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын өрөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн засаг даргын орлогч байна.

6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь 15 хүртэл гишүүнтэй байх бөгөөд (хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн гэх мэт) ажилтны төлөөлөлтэй байна. Түүнчлэн УБ хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлөөр оруулж болно.

6.3. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

6.4. Сум бүр өөрсдийн онцлогт тохирсон “Нээлттэй сум хөтөлбөр”-ийг сумын ИТХ-аар батлуулж, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.5. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах асуудлыг Ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргатай зөвшилцэж шийдвэрлэнэ.

6.6. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна. Улмаар төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

6.7. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, ИТХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.


Долоо. Хэрэгжүүлэх хугацаа

7.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- 8.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
 - 8.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;
 - 8.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусlamжийн хөрөнгө;
 - 8.1.4. Бусад.
- 8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.



Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

- 9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:
 - 9.1.1. Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 10%-иас дээш нэмэгдсэн эсэх;
 - 9.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуулчлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;
 - 9.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;
 - 9.1.4. Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;
 - 9.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлнэ.
- 9.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

---оОо---